

## Журам шинэчлэн батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжүүлж ажиллахыг төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү бүртгэлийн газар /Б.Даваахүү/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ГАНЦЭЦЭГ

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын  
202... оны ... дугаар сарын ...-ний өдрийн  
... дугаар тушаалын хавсралт

## ИЛҮҮ ТӨЛСӨН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ БУЦААН ОЛГОХ ЖУРАМ

### **НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь ажил олгогч, даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийг дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцох, буцаан олгох, хяналт тавих, тайлан гаргах, хариуцлага тооцохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

### **ХОЁР. Хамрах хүрээ**

2.1. Нийгмийн даатгалын байгууллага, нийгмийн даатгалын шимтгэл илүү төлсөн ажил олгогч, даатгуулагч (Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн).

### **ГУРАВ. Хамаарах талууд**

3.1. Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагууд.

### **ДӨРӨВ. Баримт бичгийн хариуцагч**

4.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газар

### **ТАВ. Илүү төлсөн шимтгэл буцаан авах эрх**

Дараах ажил олгогч, даатгуулагч илүү төлсөн шимтгэлээ буцаан авах эрхтэй.

5.1. Илүү төлсөн шимтгэлээ дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцох, эсхүл буцаан авахаар нийгмийн даатгалын байгууллагад хүсэлт гаргасан ажил олгогч, эсхүл сайн дурын даатгуулагч.

5.2. Сайн дураар нийгмийн даатгалын шимтгэл урьдчилан төлсөн даатгуулагч хөдөлмөр эрхэлж, албан журмаар даатгуулан давхардсан хугацааны сайн дураар төлсөн шимтгэлийг буцаан авахаар нийгмийн даатгалын байгууллагад хүсэлт гаргасан сайн дурын даатгуулагч.

5.3. Тухайн жилд хоёр ба түүнээс дээш байгууллагад хөдөлмөр эрхэлж Засгийн газрын тогтоосон тухайн үед мөрдөж буй нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээнээс хэтэрч, уг хэтэрсэн хэмжээнээс шимтгэл төлөн, илүү төлсөн шимтгэлээ буцаан авах хүсэлтээ дараа оны 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор гаргасан даатгуулагч.

### **ЗУРГАА. Ажил олгогч, даатгуулагчид буцаан олгох илүү төлсөн шимтгэлийг тооцох**

6.1. Нийгмийн даатгалын байгууллагын хүлээн авч, баталгаажуулсан ажил олгогч, эсхүл сайн дурын даатгуулагчийн шимтгэл төлөлтийн нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд тулгуурлан илүү төлсөн шимтгэлийг тооцно.

6.2. Сайн дураар нийгмийн даатгалын шимтгэл урьдчилан төлсөн даатгуулагч хөдөлмөр эрхэлж, албан журмаар даатгуулсан бол нийгмийн даатгалын байгууллагын хүлээн авч, баталгаажуулсан ажил олгогчийн шимтгэл төлөлтийн нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд тулгуурлан давхардсан хугацааны сайн дураар төлсөн шимтгэлээр буцаан олголтыг тооцно.

6.3. Тухайн жилд хоёр ба түүнээс дээш байгууллагад хөдөлмөр эрхэлж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.4-т заасан илүү төлсөн шимтгэлийг буцаан олголтыг тооцохдоо:

6.3.1. Даатгуулагч нь даатгуулагчийн нэг төрлөөр хоёр ба түүнээс дээш ажил олгогчид ажиллан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого авсан бол буцаан олгох шимтгэлийн дүнг уг цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрээс төлбөл зохих шимтгэлийг тооцон тухайн сард төлсөн шимтгэлийн зөрүү дүнгээр тооцно.

6.3.2. Даатгуулагч нь даатгуулагчийн хоёр ба түүнээс дээш ажил олгогчид ажиллан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого авсан бол буцаан олгох шимтгэлийн дүнг үндсэн ажил олгогч, зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр хөдөлмөр эрхэлж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрээс төлбөл зохих шимтгэлийг тооцон тухайн сард төлсөн шимтгэлийн зөрүү дүнгээр тооцно.

Тайлбар: “үндсэн ажил” гэж хэд хэдэн ажил олгогчтой гэрээ байгуулан ажиллах тохиолдолд долоо хоногийн ажлын цагийн ихэнхийг зарцуулж байгаа, эсхүл ажлын цагийн зарцуулалтыг тодорхойлох боломжгүй бол цаг хугацааны хувьд эхэлж гэрээ байгуулсан ажил, албан тушаалыг. /Нийгмийн даатгалын ерөнхий хууль 7.5.1 зүйл/

6.3.3. Энэ журмын 6.1, 6.2, 6.3-д заасан даатгуулагчид буцаан олгох шимтгэлийн дүнг нийгмийн даатгалын сан тус бүрд хуваарилахдаа тухайн даатгуулагчийн сан тус бүрд илүү төлсөн дүнгээр тооцно.

6.4. Ажил олгогч, даатгуулагчаас ирүүлсэн илүү төлсөн шимтгэл буцаан авах, олгохтой холбоотой өргөдөл гомдлыг Хяналт шалгалтын газар тухай бүр шийдвэрлэж ажиллана.

### **Долоо. Ажил олгогч, даатгуулагчид илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох**

7.1. Журмын 5.1, 5.2, 5.3-д заасан ажил олгогч, даатгуулагч илүү төлсөн шимтгэл авах хүсэлтээ Нийгмийн даатгалын байгууллагад цахимаар болон цаасаар гаргана. Хүсэлтэд даатгуулагчийн дахин давтагдашгүй дугаар, мөнгө хүлээн авах банк, дансны дугаар, байгууллага бол нийгмийн даатгалын байгууллага болон ажил олгогч хоорондын тооцоо нийлсэн акт байна. Дансны дугаар нь тухайн ажил олгогч, даатгуулагчийн нэр дээр бүртгэлтэй байна.

7.1.1. Журмын 5.1, 5.2-д заасан ажил олгогч, даатгуулагч цахимаар болон цаасаар хүсэлт гаргасан үед нийгмийн даатгалын байгууллагын орлого шимтгэл хариуцсан байцаагч цахим хүсэлтийг хүлээн авч, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн журмын 6.1, 6.2-ын дагуу тооцсон шимтгэлийн дүнгээр дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцно. Буцаан авах бол нийгмийн даатгалын байгууллагын сангийн нягтлан бодогч ажил олгогч, даатгуулагчийн дансанд шилжүүлнэ.

7.1.2. Журмын 5.3-д заасан даатгуулагч хүсэлт гаргасан үед нийгмийн даатгалын байгууллагын хяналт шалгалт хариуцсан байцаагч хүсэлтийг хүлээн авч, хянан баталгаажуулна. Нийгмийн даатгалын байгууллагын хяналт шалгалт хариуцсан байцаагчийн баталгаажуулсан буцаан олголтын дүнгээр нийгмийн даатгалын байгууллагын сангийн нягтлан бодогч даатгуулагчийн дансанд шилжүүлнэ.

7.2. Журмын 5.3-д заасан даатгуулагчид илүү төлсөн шимтгэлийг тухайн даатгуулагчийн өөрийн сонгосон ажил олгогчийн шимтгэлийн тооцоо хийдэг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын байгууллага олгоно.

7.3. Илүү төлсөн шимтгэл авах эрх бүхий даатгуулагч нас барсан бол нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүн бичгээр хүсэлт гаргасан үед журмын дагуу илүү төлсөн шимтгэлийг буцаан олгоно.

7.4. Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийг хүсэлт гаргасан өдрөөс хойш 30 хоногийн дотор банкаар дамжуулан олгоно.

### **Найм. Хяналт тавих, тайлан гаргах, хариуцлага тооцох**

8.1. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын Хяналт шалгалтын нэгж нь даатгуулагчид буцаан олгох илүү төлсөн шимтгэлийг тооцох, буцаан олгох үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

8.2. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь “Даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийн буцаан олголтын тайлан”-г дараа оны эхний улиралд багтаан Санхүү бүртгэлийн газарт хүргүүлнэ.

8.3. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагад илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох ажил энэ журмын дагуу хэрэгжиж байгаа эсэхийг шалгаж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

8.4. Энэ журмын 6.1- 6.3-т заасан өгөгдлийн сангийн мэдээлэлд тулгуурлан илүү төлсөн шимтгэл буцаан олгосноос хойш ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайланд өөрчлөлт орж улмаар тухайн даатгуулагчид олгосон буцаан олголтод зөрүү үүсвэл зөрүү дүнгээр даатгуулагчаар даатгалын санд төлүүлнэ. Эсхүл зөрүү дүнгээр нийгмийн даатгалын сангаас даатгуулагчид буцаан олгоно.

8.5. Энэ журмын 5-д заасан ажил олгогч, даатгуулагчаас бусад ажил олгогч, даатгуулагчид буцаан олголт хийсэн, өөр дүнгээр буцаан олголт хийсэн болон бусад зөрчил гаргасан буруутай ажилтнаар илүү төлснөөр тооцож буцаан олгосон төлбөрийг даатгалын санд төлүүлэх бөгөөд нийгмийн даатгалын ажилтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----oOo---